



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№233 /442/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.12.26

Цаг үе, үйл явдал

## ЭНХИЙГ САХИУЛАГЧИД БОЛ ХӨЛСНИЙ ЦЭРЭГ БИШ, МОНГОЛ ТӨРИЙН ЦЭРЭГ



байгаад чинь өгч буй таны цалин. Хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа та зөвхөн нөхөн төлбөр авч байгаа. Өөрөөр хэлбэл НҮБ-аас тогтоосон төлбөрийг л та авч байгаа гэсэн үг. Үүнийг буруугаар ойлгох явдал их байна. Би өмнөх ээлжүүдийн бие бүрэлдэхүүнд ч хэлсэн.

Монголын төр ямар муухай юм бэ. Энхийг сахиулагчдын цалингийнх нь 30 хувийг суутгаж авдаг, шуналтай төр гэсэн зүйл яригдаж байна. Энэ бол маш буруу ойлголт. Өнөөдөр ажиллагааны оронд томилогдож, үүрэг гүйцэтгэх гэж буй та бүхний сургалт бэлтгэлээс эхлээд тухайн бүс нутагт очих хүртэлх үйл ажиллагааг Монголын төр Батлан хамгаалах яам зохион байгуулдаг. Та бүхний сонгон шалгаруулалт, бэлтгэл сургалт, эмнэлэгийн үзлэг, шалгалт, хоол хүнс, бензин шатахуун, хувцас хангалт, сум, галт хэрэгсэл гээд олон хүний хүч хөдөлмөрөөс гадна их хэмжээний зардал гардаг гэдгийг ойлгох хэрэгтэй.

Улсын Зэвсэгт хүчин чадавхиж байгаа юм. Эцсийн дүндээ бид эх орноо найдвартай хамгаалж чадах цэргийн алба хаагчидтай болж байгаа юм.

Саяхан надад ажиллагааны орноос “Энхийг сахиулагчаас илгээж буй гунигт захидал” хэмээн хаягласан захидал ирснийг та бүхэн бүгд уншсан байх. Тухайн захидалд “Энд буй дарга, удирдлагууд энгийн биднийг шулан мөлжиж байна гэсэн утгатай”. Асуудлыг нуужаалгүй ил ярих нь зөв. Захидлын мөрөөр удирдлагуудтай нь холбогдож, тэр дор нь арга хэмжээ авсан. Шударга бус үйлдлийг илчилж, захидлыг илгээсэн алба хаагчид би баярлаж байгаа. Ахиж ийм зүйл цаашид гарахгүй байх гэдэгт итгэлтэй байна. Энэ удаагийн бие бүрэлдэхүүнтэй Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсгийг албан ёсоор томилон явуулж

Миний бие 1985 оны намар анх цэргийн тангараг өргөж байлаа. Түүнээс хойш нэг өдөр ч энэ салбараас нүүр буруулж өөр салбар луу явья гэсэн бодол төрж байсангүй. Мөн халагдаж чөлөөлөгдсөнгүй. Цэргийн хүний хүлээх үүрэг хариуцлага тушаал, шийдвэр бүрийг биелүүлж, шат дараалсан албан тушаалуудад ажиллаад, өнгөрсөн 2020 оноос улс төрийн албан тушаал буоу салбарын сайдын албанд томилогдсон.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд манай цэрэг дайчид дэлхийн энх тайвны үйл хэрэгт бодит хувь нэмрээ оруулж ирсэн. Энэ бол Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хүлээлгэж буй Төрийн даалгавар. Гэхдээ хэн ч таныг хүчлээгүй та бүхэн өөрсдөө сайн дурын үндсэн дээр шийдвэр гаргаж, ажиллагааны газар орон руу явж байгаа гэдгээ санах хэрэгтэй.

Та бүхэн НҮБ-аас өгсөн үүргийн дагуу тухайн бүс нутгийн ард иргэдийг мөргөлдөөн үймээнээс хамгаалах, амьд явах эрх чөлөөг нь хангах зорилготой үүрэг гүйцэтгэж байгаа юм. Энэ бүхэн чинь дэлхийн энх тайвны төлөө оруулж буй цэрэг таны хувь нэмэр. Өчигдөр миний бие цэрэг хүний хувиар НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд явах гэж буй алба хаагчидтай уулзаж, үүрэг чиглэл, зөвлөгөө өгснийг энд товч сийрүүлэн үлдээе гэж бодлоо.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд манай үе үеийн энхийг сахиулагч нар үүргээ нэр төртэй биелүүлж ирснийг та бүхэн надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Тиймдээ ч өнгөрсөн наймдугаар сард НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио

Гутерреш манай улсад айлчилсан. Энэ бол Монгол цэрэг- Дэлхийн цэрэг болсон гэдгийн баталгаа юм.

Өнөөдөр дэлхий ертөнц маш том сорилын өмнө ирээд байна. Дэлхийн зарим тив, бүс нутгийн хэмжээнд цэрэг-улс төрийн нөхцөл байдал эдрээтэй, тогтворгүй байна. Дэлхийн хэмжээнд явагдаж буй нийт дайн, зэвсэгт мөргөлдөөний 80 орчим хувь нь Европ, Ази болон Африк тивд өрнөж байна. Ийм л газарт та бүхэн үүрэг гүйцэтгэхээр явж байна. Ер нь ажиллагааны оронд үүрэг гүйцэтгэнэ гэдэг бол Эрсдэлтэй. Энхийг та бүхэн маш сайн ойлгох хэрэгтэй.

Мэдээж бидэнд ололттой талуудын хажуугаар дутагдалтай зүйлс байгаа ч нуух юун. Ажиллагаанд явж буй цэргийн алба хаагчдын сонгон шалгаруулалт дээр алдаа мадаг гардаг, танил тал хардаг, шударгаар өргөдлөө өгөөд, ээлжээ хүлээж буй алба хаагчдын өмнүүр орж, ажиллагаанд олон удаа явдаг зэрэг олон зүйл яригддаг. Ийм байдал удаан үргэлжилбэл шударгаар явж байгаа алба хаагчид зэвсэгт хүчиндээ итгэх итгэлгүй болно. Тиймээс иймэрхүү асуудлуудыг цаашид таслан зогсоож, цэгцэлнэ.

Та бүхэн бол Төрийн томиллоотор явж, үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагч нар. Та нар бол хөлсний цэрэг биш. Та бүхэн бол Монгол төрийн цэрэг. Монгол Улсынхаа төлөө амь насаа зориулна гэж тангараг өргөсөн алба хаагч нар. Манай цэргийн алба хаагч нар ажиллагааны оронд үүрэг гүйцэтгэхдээ энд авч байсан цалингаа 100 хувь авдаг. Тэр бол Монголын төрөөс та бүхэнд цэргийн албаа хааж байгаа, албан үүргээ гүйцэтгэж



Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль, Засгийн газрын тогтоолоор нөхөн төлбөрийн 30 хувийг сургалт, бэлтгэлийг хангахад, 70 хувийг нь цэргийн алба хаагчид олгох талаар заасан байдаг. Дэлхийн бусад орны жишгийн дагуу 2003 оноос хойш хэрэгжээд явж байгаа журмыг мушгин гуйвуулж байгаа нь харамсалтай. Энэ журмаа ч мэдэхгүй манай алба хаагчид ажиллагаанд явах гээд байдаг. Иймээс энэхүү журмаа сайн уншиж судлах хэрэгтэй. НҮБ-аас та нарт цалин олгодоггүй, та нар харин тэнд үүрэг гүйцэтгэснийхээ төлөө нөхөн төлбөр авч байгаа юм.

Дараагийн хэлэх зүйл бол та бүхэнд ажиллагааны оронд үүрэг гүйцэтгэж байх явцдаа өөрийгөө хөгжүүлэх маш олон боломж байна. Жишээлбэл: хэл сурах, бие бялдраа хөгжүүлэх, бясалгал хийх, компьютерын мэдлэгээ дээшлүүлэх зэрэг олон боломж байна. Цэргийн хүний хувьд боловсроод, өрхийн тэргүүн, айл гэрийн эзэгтэй хүний хувьд өөрийнхөө амьдралын мөн чанар, бодол сэтгэл, бүх зүйлээ цэгцлээд ирнэ. Олон талын боломжууд байсан учраас л аль 20 жилийн өмнөх төр засгийнхан олж хараад, мэргэн шийдвэр гаргасан байгаа юм. Үр шим нь Монгол Улсын нэр хүнд дэлхийд үнэлэгдэж, Монгол

байгаа. Өмнө нь явуулж байсан ч энэ удаагийнх бол болохгүй, бүтэхгүй байгаа асуудлыг шийдвэрлэх зорилготой явна. Тухайлбал алба хаагчдын ажиллах, амьдрах орчин, хангалт, үүрэг гүйцэтгэх нөхцөл байдал, зэвсэг техникийн асуудалтай нэг бүрчлэн танилцана.

Эцэст нь хэлэхэд цэргийн хүн дэгтэй, журамтай байх ёстой хэдий ч амаа үдүүлсэн мэт яв гэсэн үг биш юм. Асуудал байвал шат шатны дарга удирдлагууддаа уламжил. Цэргийн хүнд итгэлцэл гэдэг бол маш чухал. Миний хувьд салбарын сайд болсноос хойш Шударга, Хариуцлагатай, Зөв хандлагатай байцгаая гэдгийг байнга хэлж, захиж байгаа. Энэ зарчмыг л баримталцгаая. Бие биенээ хүндэлдэг, тусалж, дэмждэг байцгаая. Ялангуяа хүний нутагт үүрэг гүйцэтгэх гэж байгаа та бүхэн нэг нэгэндээ дэмтэй, ажил үүргээ хийвэл хийсэн шиг хийчихдэг, харилцан хүндэтгэлтэй хандаж яваарай. Цаашид ажиллагааны шинэчлэлийг доривтой хийх болно.

Дэлхийд данстай улс эх орныхоо батлан хамгаалагч та бүхэн минь төрөөс өгсөн үүрэг даалгавраа нэр төртэй биелүүлээд ирэхийг хүсэн ерөөе.



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-26

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	20

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.462	3.468
EUR	3.670	3.695
CNY	490	492
RUB	48.60	50
JPY	25.90	26,20
KRW	2.68	2.71

### ЗУРХАЙ

2022.12.26 / ДАВАА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 3

**ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР**  
**ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**Эд мал баялаг төгөлдөр болно**  
**Наран ургах, шингэх:**  
**08.41-17.04**  
**Барилдлага:**  
**Идэр**  
**Шүтэн барилдлага:**  
**Хуран үйлдэхүй**

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол


Нийт: 661,888,237

Эдгэрсэн

Нийт: 634,436,942

Нас барсан

Нийт: 6,686,495



Цаг үе, үйл явдал

ГАРДАН ТУЛААНЫ АВАРГУУДАА ТОДРУУЛЛАА



Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Зэвсэгт хүчний аварга шалгаруулах "Гардан тулаан"-ы тэмцээнд анги хамт олноо төлөөлөн оролцох тамирчдыг сонгон шалгаруулах зорилгоор ангийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнийг нээж ангийн захирагч хурандаа М.Болдбаатар үг хэлсэн бөгөөд энэ үеэр тус ангийн сургалт бэлтгэлийн материал хэрэгсэлд дэмжлэг үзүүлэн 12 ширхэг кимоног хандивлалаа.

Тэмцээнийг 6 жингийн ангилалтай зохион байгуулсан

бөгөөд офицер, ахлагч, цэргийн хүрээ, хотхоны бие бүрэлдэхүүн хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, аваргуудаа тодрууллаа.

Тэмцээний өмнөх өдөр тамирчдын биеийн жинг үзэж, сугалаагаар оноолтыг хийсэн ба тэмцээн эхлэх өдөр эмчийн үзлэгт хамруулж аюулгүй ажиллагааны анхан болон давтан зааварчилгааг танилцуулан ажилласан юм.

Тэмцээний нэгдсэн дүнгээр тэргүүн байрт Сонсголон цэргийн хүрээний баг, дэд байрт тус ангийн Хүндэт харуулын тусгай ротын баг, гутгаар байрт Харуул үйлчилгээний тусгай ротын баг тамирчид шалгарч бусад нөхдөө манлайллаа.



ҮБХИС-ИЙН СОНСОГЧИД САЙН ҮЙЛСИЙН АЯНД...



Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Сонсогчийн батальоны ахлах дэслэгч Б.Намхайноров ротын захирагчтай офицер, ахлагч БХМСҮТ-ийн сонсогчид ирж буй 2023 оныг угтаж сайн үйлсийн аяныг зохион байгуулсан бөгөөд тус хамт олон 100 гаруй бяцхан үрсийг баярлуулж гарын бэлэг тараажээ.

АНГИЙН АХЛАГЧ НАРЫН ЦУГЛАРАЛТААР...



Зэвсэгт хүчний 339 дүгээр анги нь 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу ангийн ахлагч нарын заах арга зүйн цугларалтыг зохион байгууллаа.

Уг үйл ажиллагааны хүрээнд ангийн ахлагч, сургагч ахлагч О.Буяндалай "Зэвсэгт хүчний ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр" баримт бичгийг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн бол ҮБХИС-ийн МСҮТ-ийн эрдэм шинжилгээний сургалтын албаны дарга тэргүүн ахлагч доктор Ц.Оюунчимэг "Ахлагчийн манлайлал-сургалт бэлтгэл", Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн ахлагч, тэргүүн ахлагч Ч.Түвшин "Цэргийн алба сахилга, зохион байгуулалт", Чадварлаг боловсон хүчин ТББ-ын тэргүүн Д.Одончимэг "Хувь хүний санхүүгийн боловсрол" сэдвээр тус тус онлайн-аар холбогдож лекц уншлаа.

Цугларалтын төгсгөлд АУТ-ийн ажиллагааны ахлагч Э.Амарбуян ахлагчийн цалин хөлс, тэдний ар гэрт тулгамдаж буй асуудал сэдвийн хүрээнд бие бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлгийг зохион байгуулав.

ХОВД АЙМГИЙН ТҮҮХ, ДУРСГАЛЫН ГАЗРУУДААР АЯЛАВ



бүсийн тулгуур төв Ховд хоттой танилцах нэгэн өдрийн аяллыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан юм.

Энэ үеэр Ховд аймгийн музей, Олон ястны өв, соёлын өргөөг үзэж тайлбартай аялалд хамрагдлаа. Мөн Галдан бошигт хааны хөшөө, Ард Аюушийн талбайд дурсгалын зураг татуулсан бөгөөд Хатанбаатар С. Магсаржав авар удирдуулсан их цэрэг 1912 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 250 гаруй жилийн түүхтэй Ховд хотыг чөлөөлсөн түүхийг илтгэсэн эртний түүхт Сангийн хэрэмтэй танилцаж, өөрсдийн мэдлэгээ дээшлүүлэв.

Дараа нь Соёмбот уул Баатар хайрхан ууландаа

очсоноор дээрх аялал өндөрлөсөн юм. Ийнхүү тэд нэгэн өдрийг инээд хөөр, дуу хууртай өнгөрүүлснээр өөрсдийн танин мэдэхүй, мэдлэгийн санг хөгжүүлсний хамтаар монгол түмний бахархал болж, түүхэнд алдаршсан эх оронч зүтгэлтнүүдээр бахдан омогшиж, эрх чөлөө, тусгаар тогтнол асар их үнээр олдсоныг мэдэрч ухаарсан дурсамж дүүрэн аялал болов.

Дэд ахлагч П.МАНДАХЦЭЦЭГ



Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит, Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Соёл хүмүүжлийн албанаас цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хааж буй түүрүүч, байлдагч нартай Баруун

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №44

РА ҮСЭГ БҮХИЙ УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА  
Бидний үзэж буй РА гийгүүлэгч бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй их төлөв таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүй сайхан бичиж, хөрвүүлэгтүн.

Дармал, бичмэл тигээр:

